



**НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР
ХҮҮХДИЙН СЭРГЭЭН ЗАСАХ ЭРҮҮЛ ҮРС ТӨВИЙН
ДАРГЫН ТУШААЛ**

2021 оны 06 сарын 17 өдөр

Дугаар А/53

Улаанбаатар хот

Аюулгүй байдалтай холбоотой алдаанаас хохирсон
үйлчлүүлэгчид дэмжлэг үзүүлэх журам батлах тухай

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 5, 13 дугаар зүйл,
Эрүүл Мэндийн Сайдын 2019 оны А/566 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтыг
тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлэх явцад гарч болзошгүй алдаанаас урьдчилан сэргийлэх зорилгоор “Аюулгүй байдалтай холбоотой алдаанаас хохирсон үйлчлүүлэгч нарт дэмжлэг үзүүлэх журам”-ыг хавсралтаар баталсугай.
2. Журмын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан орон тооны бус гишүүн, Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдлын багийн гишүүдэд үүрэг болгосугай.
3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод хяналтын багийн ахлагч /Ж.Цэвээндулам/-д даалгасугай.

ДАРГА Ш.Саруултуяа Ш.САРУУЛТУЯА



Нийслэлийн хүүхдийн сэргээн засах Эрүүл үрс
төвийн даргын 2021 оны 06 сарын 17 өдрийн
А/53 дугаар тушаалын хавсралт

АЮУЛГҮЙ БАЙДАЛТАЙ ХОЛБООТОЙ АЛДААНААС ХОХИРСОН ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГҮНДЭСЛЭЛ

Энэхүү журам нь эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах зорилгоор үйлчлүүлэгчийн аюулгүй байдалд нөлөөлөх эрсдэлт хүчин зүйлийг эрт илрүүлж, засаж залруулах, давтан гарахаас урьдчилан сэргийлэх, аюулгүй байдалтай холбоотой алдаанаас хохирсон үйлчлүүлэгч нарт дэмжлэг, тусламж, үйлчилгээг үзүүлэх арга хэмжээг зохицуулахад оршино.

ХОЁР. ХАМРАХ ХҮРЭЭ

Тус Сэргээн засах төвөөр үйлчлүүлж буй үйлчлүүлэгчид

ГУРАВ. ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙ, ХАЛДВАРААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

- 3.1 Сэргээн засах төв нь тухайн төвөөр үйлчлүүлж буй иргэдэд халдварт өртөх эрсдлийн үнэлгээ хийх
- 3.2 Үйлчлүүлэгч болон түүний ар гэрийнхэнд шаардлагатай мэдээлэл өгөх
- 3.3 Халдвараас сэргийлэх дэглэмийг чанд баримтлан сэргээн засах төвийн орчинд, ариун багаж хэрэгслээр үйлчлүүлэгчдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх
- 3.4 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага, стандартыг хэрэгжүүлэх байнгын хяналтын тогтолцоог хангах
- 3.5 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаарх мэдээллийн ил тод, үнэн бодит байдлыг хангах
- 3.6 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн нөхцөлийг бүрдүүлсэн байх.
- 3.7 Галын дохиолол болон гал унтраах тусгай тоноглол, гарц, орцын зураглалыг гал гарч болзошгүй ажлын байр бүрт байрлуулан, тэдгээрийг тогтмол ажиллагаатай байлгаж, үйлчлүүлэгчдэд ил тод байдлаар мэдээлсэн байх.

ДӨРӨВ. ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙН ХҮРЭЭ

Шууд буюу байгууллагын үйл ажиллагаатай холбоотой эрсдэлд өртсөн

үйлчлүүлэгчдэд хамаарна.

- 4.1 Үйлчлүүлэгчид эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой үүссэн эрсдэл
- 4.2 Үйлчлүүлэгч эмч, ажилчдын харилцаа, хандлагаас үүдэн гарсан эрсдэл
- 4.3 Эмч, эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн ур чадвар, тусламж үйлчилгээ, оношилгоо, эмчилгээний түгээмэл үйлдлийн стандарт, эмнэлзүйн удирдамжийн хэрэгжилт, мөрдөлттэй холбоотой үүссэн эрсдэл
- 4.4 Эмч, эмнэлгийн ажилчдын мэдлэг, ур чадвар, түүнтэй холбогдон гарсан эрсдэл
- 4.5 Эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдвар (Эрүүл мэндийн байгууллагад хийгдсэн эмчилгээ, үйлчилгээний явцад үйлчлүүлэгч шинээр халдвар авч, халдварын шинж тэмдэг нь эмнэлэгт үйлчлүүлснээс хойш 24 цаг ба түүнээс хойшхи хугацаанд эмнэлгээс гарсны дараах 1 сар, эрхтэн шилжүүлэн суулгах, хиймэл эд эрхтэн суулгах ажилбарын дараах 1 жил хүртэл хугацаанд илэрсэн халдвар)

ТАВ. ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АЮУЛГҮЙ БАЙДАЛТАЙ
ХОЛБООТОЙ АЛДААНААС ХОХИРСОН ҮЙЛЧЛҮҮЛЭГЧ НАРТ ҮЗҮҮЛЭХ
ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ, АВАХ АРГА ХЭМЖЭЭ

- 5.1 Халдвараас сэргийлэх арга хэмжээ авч, нарийн мэргэжлийн эмч, мэргэжилтний зөвлөгөө, анхны тусламжийг цаг алдалгүй үзүүлж, шаардлагатай үзлэг шинжилгээнд (цусаар дамжих халдварыг илрүүлэх оношилгоо шинжилгээ) хамруулна.
- 5.2 Үйлчлүүлэгч халдвар авах эрсдэлт хүчин зүйлд өртсөн болон аюулгүй байдалтай холбоотой алдаанаас хохирсон тохиолдолд үйлчлүүлэгч болон түүний асран хамгаалагчид мэдэгдэнэ.
- 5.3 Шаардлагатай тохиолдолд үйлчлүүлэгчийг Сэргээн засах төвийн даргын 2021 оны “Өвчтөн шилжүүлэх журам” А/14 тоот тушаалын дагуу дараагийн шатлалын эрүүл мэндийн байгууллагад шилжүүлэн тусламж, үйлчилгээг үзүүлнэ.
- 5.4 Галын аюулгүй байдлыг хангах талаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эрх, үүрэг, хариуцлагыг Галын аюулгүй байдлын тухай 3, Зөрчлийн тухай хуулийн 5.14 дүгээр заалтаар зохицуулна.
- 5.5 Аюулгүй байдалтай холбоотой алдаанаас хохирсон үйлчлүүлэгчид анхны тусламж үйлчилгээг үзүүлсэн эмч, эмнэлгийн мэргэжилтэн Сэргээн засах төвийн даргын 2021 оны “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээтэй холбоотой

үүссэн тохиолдлыг бүртгэх, хариу арга хэмжээ авах, мэдээлэх журам батлах тухай 2021.03.25 А/21 тоот тушаалын хоёрдугаар хавсралтын дагуу алдаа, зөрчлийг бүртгэх, мэдээлэх хуудсаар мэдээллийг бүртгэн тасгийн эрхлэгч, ахлах сувилагчид болон ЭМТҮЧАБ-ын багт мэдээллэнэ.